

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2025 оны 09 дүгээр сарын 16

Орхон аймаг

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц
ЗГ-ын тогтоол				
65	95	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_56	2.19.. цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга), аймгийн Засаг дарга нарт.	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллаж байна. 2025 оны 9 сарын 16-ны байдлаар анхааруулга мэдээ 32 удаа, сэрэмжлүүлэг мэдээ 11 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 1 удаа зохиож мэдээлэв. Цаг агаарын мэдээлэл үйлчилгээг утсаар -7 байгууллага, аж ахуй нэгжид, мэйл хаягаар-57 хүнд, и-оффисоор төрийн албан хаагч-2542 хүнд, масс мессэжээр аймгийн Онцгой комиссын 36 гишүүд, дарга нар 25, багийн засаг дарга 25, Жаргалант сумын ИТХ, багуудын ажлын алба 11, Барилга захиалагчийн алба, барилга замын компани 22, Жаргалант сумын малчид, тариаланчид, ногоочид 83, нийт 2023 хүнд гар утсанд цаг агаарын мэдээг тогтмол хүргэж байна. Зуны улирлын анхааруулах мэдээ буюу дуу цахилгаантай аадар бороо, үер уснаас анхааруулах мэдээ 5 удаа, их халуун 1 удаа зохиосон. 2025 оны 9 сарын 16-ны байдлаар Баян-Өндөр суманд орон шуурга 5 удаа, нойтон цас 11 удаа, хүчтэй салхи 1 удаа, мөндөр 6 удаа, нөөлөг салхи 5 удаа өгч нийт 28 удаагын

				аюул мэдээ. Жаргалант суманд орон шуурга 8 удаа, нойтон цас 4 удаа, хүчтэй салхи 1 удаа, мөндөр 2 удаа, нөөлөг салхи 2 удаа өгч нийт 17 удаагын аюул мэдээ ажиглагдсан байна. Сар болон улирлын төлвүүдийг тус бүр гаргаж и-office, Orkhon.weather.gov.mn, байгууллагын фэйсбүүк хаяг, e-mail бүртгэлтэй 57 хаягуудад илгээж, байршуулсан. Масс мессэж дэх Орхон аймгийн Онцгой комиссын гишүүдийн нэрс болон утасны дугаарыг шинэчилж өөрчлөв. Уг хүрээнд байгууллагын фэйсбүүк хаягийг идэвхжүүлж, хуурайшилтын зэрэг, үер усны аюул, гэнэтийн дуу цахилгаантай аадар борооноос анхааруулах мэдээг эрчимтэй явуулав Үр нөлөө: Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид цаг алдалгүй, шуурхай хүлээн авч урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна. 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажил хангагдсан байна. Цаг хугацааны хоцрогдолгүй агаар, хөрс, усны болон уур амьсгал, цаг агаарын нөхцөл байдлын мэдээгээр хангагдсан байна. Шинжилгээ, судалгааны хэрэгжилтийн үр дүн, нөхцөл байдлын болон учирч болох эрсдэл, үйл явцын талаарх мэдээллийг танилцуулсан байна.
3Г-ын хуралдааны тэмдэглэл				
116	172	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-30	21.11.10.1.. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлж, иргэдэд хүргэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол үр дүнтэй явуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	ОБГ 2025 оны 09 дгээр сарын 15-ны байдлаар ойн түймэр гарах нөхцөлийг хуурайшлын зэргээр тодорхойлоход Баян-Өндөр сумаар ой хээрийн түймрээс анхааруулах мэдээ 29 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 21 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 23 удаа гаргасан бол Жаргалант сумаар ой хээрийн түймрээс анхааруулах мэдээ 29 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 18 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 28 удаа тус тус гаргасан байна. http://orkhon.weather.gov.mn/, Ус цаг уур орчны

		Дугаар 2025_21		шинжилгээний төв фэйсбүүк хаяг, урсдаг самбар, alarm.tsag-agaag.gov.mn, Е-оффис, е-мэйл хаягаар шуурхай мэдээллэж, мөн ОБГазар Саруул, Сум дундын ой ангийн дарга Энхбазар, БОАЖГазрын мэргэжилтэн Батсайхан нарт е-оффисоор мэдээлэлийг тухай бүр нь хүргэсэн. Үр нөлөө: Шуурхай арга хэмжээ авч урьдчилан сэргийлж ажилладаг.
121	177	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-20 Дугаар 2025_13	12.3.2.2.. нийслэл, төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг 3 жилийн дотор Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	ХБТХОХ БОГ УЦУОШТ МУ-ын БОУАӨЯ, БНСУ-ын БОЯ-ны хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар Орхон аймагт анхны 6 үзүүлэлтээр үздэг агаарын чанарын автомат станцыг суурилуулсан. Тус автомат станц нь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрс төрөгчийн дутуу исэл, РМ10 тоосонцор, РМ2,5 тоосонцор, Озон гэх мэт байгаль орчны суурь үзүүлэлтүүдийг 24 цаг, 365 хоног тасралтгүй хэмжих хүчин чадалтай. Нийт 21 аймагт суурьлуулсаны дараа дотоод сүлжээнд холбогдох тул туршилтаар мэдээгээ авч ажиллаж байна. Үр нөлөө: Агаарын чанарын автомат станц тавигдсанаар агаарын чанарын 6 үзүүлэлтийг цаг алдалгүй авах боломж нээгдэнэ.
	178		12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль,	ХБТХОХ БОГ

		цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус;	УЦУОШТ нь дотоод орчны агаарын чанарын стандарт хэмжилтийг хэмждэггүй бөгөөд гадаад орчны ба агаар, хөрс, усны шинжилгээг хийдэг. Дотоод орчны агаарын чанарын стандарт шинжилгээ хийдэг ганц нэг сургууль байдаг гэж сонссон. Манай төвд хамааралгүй заалт байна.
	179	12.3.2.6.. угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн гэр хорооллын өрх бүрд байршуулж, хяналт тавин, мэдрэгч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	ХБТХОХ БОГ УЦУОШТ Манай төвд хамааралгүй заалт байна.
	180	12.3.2.7.. агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн сувгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	ХБТХОХ БОГ УЦУОШТ Орхон аймгийн агаарын чанарын хөтөлбөрт хяналт шинжилгээг 3-р улирлын байдлаар хотын төв болон гэр хороолол орчмоос хүхрийн давхар исэл 174 удаагийн давталттай, азотын давхар исэл 174 удаагийн давталттай тус тус хяналт-шинжилгээ хийлээ. Хөтөлбөрт бус агаарын хяналт шинжилгээг аж ахуйн нэгжид 21 удаа хийсэн байна. Агаарын чанарын индексээр 8 дугаар сарын хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 2 мкг/м³ хүрч агаарын чанарын MNS4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Хамгийн их агууламж

				гэр хороолол орчим 10 мкг/м³ буюу ХА-аас даваагүй байна. Агаарын чанарын индексээр цэвэр буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Азотын давхар ислийн хяналт шинжилгээний дүнгээр дундаж агууламж 74 мкг/м³ хүрч Агаарын чанарын MNS 4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Хамгийн их агууламж хотын төв орчим 212 мкг/м³ буюу ХА-аас 1 дахин давсан байна. 9 дүгээр сарын эхний 10 хоногийн хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 3 мкг/м³ хүрч агаарын чанарын MNS4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Хамгийн их агууламж хотын төв орчим 7 мкг/м³ буюу ХА-аас даваагүй байна. Агаарын чанарын индексээр цэвэр буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Азотын давхар ислийн хяналт шинжилгээний дүнгээр дундаж агууламж 123 мкг/м³ хүрч Агаарын чанарын MNS 4585:2025 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Хамгийн их агууламж хотын төв орчим 360 мкг/м³ буюу ХА-аас 2 дахин давсан байна. Агаарын чанарын индексээр бага бохирдолтой буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хяналт шинжилгээний үр дүнг өдөр бүрийн дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн санд, агаарын чанарын хяналт шинжилгээний мэдээг агаарын чанарын индексээр үнэлэн өдөр бүр БОУАӨЯ, ОББҮХ, ЦУОШГ-т газарт, сар бүрийн статистик мэдээ болон тайланг ЦУОШГ-ын Орчны шинжилгээний хэлтэст, Орхон аймгийн Статистикийн газарт, сар бүрийн статистик мэдээг аймгийн ХБТХОХ, БОГ, ЭМГ-т хүргүүлэн ажиллаж байна. Сар бүрийн агаарын чанарын тайлан мэдээг https://weather.gov.mn/ сайтад оруулан ард иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.
--	--	--	--	---